



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2010 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дарга / Д.Мөрөнд /-д даалгасугай.


3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2006 оны 87 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.НЯМДОРЖ

96420206



ГАДААДЫН ИРГЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энэхүү журмаар Монгол Улсад амьдарч байгаа гадаадын иргэдийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, түүнийг байгууллагын хэмжээнд ашиглах үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Мэдээллийн нэгдсэн сангаас байгууллага хооронд цахим хэлбэрээр мэдээлэл харилцан солилцох, сүлжээний болон мэдээллийн нууцлалыг хангах үйл ажиллагааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 99 дугаар тушаалаар баталсан "Мэдээллийн нэгдсэн сүлжээ болон толгой компьютерийг ашиглах, түүний нууцыг хэдгалах, хамгаалах журам"-аар зохицуулна.

1.3. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар /цаашид "Газар" гэх/ нь гадаадын иргэний талаархи мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, нууцлалыг хангах үйл ажиллагааг бүрэн хариуцна.

1.4. Мэдээллийн нэгдсэн сан нь дараах дэд сангуудаас /цаашид "мэдээллийн сан" гэх/ бүрдэнэ:

1.4.1. Гадаадын иргэнд олгох зөвшөөрөл, бүртгэлийн мэдээллийн сангууд:

1.4.1.1. Монгол Улсад оршин суух гадаадын иргэний мэдээллийн сан;

1.4.1.2. Монгол Улсад түр ирэгч гадаадын иргэний мэдээллийн сан;

1.4.1.3. Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олголтын мэдээллийн сан;

1.4.1.4. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаадын иргэний талаар Хөдөлмөр

халамжийн үйлчилгээний газарт явуулсан санал болон гадаадын иргэний тодорхойлолтын мэдээллийн сан;

1.4.1.5. Монгол Улсын визийн зөвшөөрөл олгосон мэдээллийн сан;

1.4.1.6. Монгол Улсын виз олголтын мэдээллийн сан.

1.4.2. Иргэний харьяаллын мэдээллийн сангууд:

1.4.2.1. Монгол Улсын харьяатаас гаргасан иргэний мэдээллийн сан;

1.4.2.2. Монгол Улсын харьяат болсон иргэний мэдээллийн сан;

1.4.2.3. Иргэний харьяаллаа сэргээлгэсэн иргэний мэдээллийн сан;

1.4.2.4. Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэний мэдээллийн сан;

1.4.2.5. Гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн

мэдээллийн сан.

1.4.3. Гадаадын иргэний хяналт, шалгалтын мэдээллийн сан:

1.4.3.1. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээллийн сан;

1.4.3.2. Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэний мэдээллийн

сан;

1.4.3.3. Ял шийтгэгдсэн гадаадын иргэний мэдээллийн сан;

1.4.3.4.Виз, бүртгэлийн журам зөрчиж хариуцлага хүлээсэн гадаадын иргэний мэдээллийн сан;

1.4.3.5.Нийгмийн хэв журам зөрчиж, хариуцлага хүлээсэн гадаадын иргэний мэдээллийн сан;

1.4.3.6. Виз, бүртгэлийн журам зөрчиж шийтгэл хариуцлага хүлээсэн уригч байгууллага, иргэний мэдээллийн сан.

Хоёр. Гадаадын иргэний зөвшөөрөл, бүртгэлийн мэдээллийн сан

2.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.5, 5.1.6 дахь заалтад хамаарах, Монгол Улсад оршин суух гадаадын иргэний мэдээллийн сан нь дараах мэдээллийг агуулсан байна:

2.1.1.овог, эцэг/эхийн нэр, өөрийн нэр;

2.1.2.төрсөн он, сар, өдөр;

2.1.3.хүйс;

2.1.4.иргэний харьяалал, яс үндэс;

2.1.5.паспортын дугаар, дуусах хугацаа;

2.1.6.зураг;

2.1.7.хил нэвтрэлтийн мэдээлэл;

2.1.8.визийн мэдээлэл;

2.1.9.регистрийн дугаар;

2.1.10.бүртгэлийн дугаар, он, сар, өдөр;

2.1.11.Монгол Улсад оршин суугаа хаяг;

2.1.12.оршин суух зөвшөөрлийн мэдээлэл /төрөл, цуврал дугаар, хүчинтэй хугацаа,

сунгалт/;

2.1.13.гэр бүлийн гишүүд;

2.1.14.ажил эрхлэлтийн мэдээлэл;

2.1.15.зөрчлийн тэмдэглэл;

2.1.16.гарын хурууны хээ /албан болон хувийн хэргээр оршин суугч/.

2.2.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.4 дэх заалтад хамаарах, Монгол Улсад түр ирэгч гадаадын иргэний мэдээлэл нь энэ журмын 2.1.1.-2.1.8.-д заасан мэдээлэл уригчийн мэдээллээс бүрдэнэ.

2.3.Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олголтын мэдээллийн сан нь дараах мэдээллийг агуулсан байна:

2.3.1.Уригч иргэний талаарх мэдээлэл:

2.3.1.1.энэ журмын 2.1.1.- 2.1.2.-д заасан мэдээлэл /Монгол Улсын иргэний хувьд/;

2.3.1.2.регистрийн дугаар /Монгол Улсын иргэний хувьд/;

2.3.1.3.иргэний үнэмлэхний дугаар /Монгол Улсын иргэний хувьд/;

2.3.1.4.харьяалах улсын нэр /гадаадын иргэний хувьд/;

2.3.1.5.оршин суугаа хаяг;

2.3.1.6.гадаадын иргэний хувьд энэ журмын 2.1.1.- 2.1.5., 2.1.8. -2.1.11.-д заасан мэдээлэл.

2.3.2.Уригч аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээлэл:

- хугацаа;
- 2.3.2.1.байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, хүчинтэй
 - 2.3.2.2.гадаадын хөрөнгө оруулалттай компани, аж ахуйн нэгж бол сертификатын дугаар;
 - 2.3.2.3.үйл ажиллагааны чиглэл;
 - 2.3.2.4.тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл /тусгай зөвшөөрлийн төрөл, олгосон газар, төрөл, дугаар, хүчинтэй хугацаа/;
 - 2.3.2.5.захирлын регистрийн дугаар, бүртгэлийн дугаар;
 - 2.3.2.6.тусгай тэмдэглэл.

2.3.3.Уригдагчийн талаарх мэдээлэл:

- 2.3.3.1.энэ журмын 2.1.1.-2.1.5.-т заасан мэдээлэл;
- 2.3.3.2.гадаадад оршин суугаа хаяг;
- 2.3.3.3.Монгол Улсад байх хаяг;
- 2.3.3.4.Монгол Улсад байх хугацаа;
- 2.3.3.5.урилгын дугаар, олгосон он, сар, өдөр.

2.4.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаадын иргэний талаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт явуулсан санал болон гадаадын иргэний виз, бүртгэлийн талаарх тодорхойлолтын мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1.- 2.1.5.-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулсан байна:

- 2.4.1.санал өгсөн он, сар, өдөр;
- 2.4.2.зөвшөөрлийн төрөл, дугаар;
- 2.4.3.зөвшөөрөл олгосон үндэслэл;
- 2.4.4.зөвшөөрөл олгосон газар;
- 2.4.5.визийн зэрэг, ангилал;
- 2.4.6.хүчинтэй хугацаа;
- 2.4.7.ажиллах байгууллагын регистрийн дугаар, нэр;
- 2.4.8.ажиллах байгууллагын үйл ажиллагааны төрөл;
- 2.4.9.ажиллах байгууллагын хаяг.

2.5.Монгол Улсын визийн зөвшөөрөл олгосон мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1.- 2.1.5.-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулсан байна:

- 2.5.1.үндэслэл;
- 2.5.2.зөвшөөрлийн дугаар;
- 2.5.3.зөвшөөрөл олгосон он, сар, өдөр;
- 2.5.4.зөвшөөрөл олгосон газар;
- 2.5.6.визийн зэрэг, ангилал, ялгаа;
- 2.5.7.хүчинтэй хугацаа;
- 2.5.8.визийн зөвшөөрөл хүргүүлсэн газар.

2.6.Монгол Улсын виз олголтын мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1.- 2.1.6.-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулсан байна:

2.6.1.Визийн мэдээлэл:

- 2.6.1.1.зэрэг, ангилал, төрөл;
- 2.6.1.2.хүчинтэй хугацаа;
- 2.6.1.3.олгосон он, сар, өдөр, газар;
- 2.6.1.4.тусгай тэмдэглэл.

2.6.2.Гадаадын иргэний талаарх энэ журмын 2.1.1.-2.1.6.-д заасан мэдээлэл.

Гурав Иргэний харьяаллын мэдээллийн сан

3.1.Монгол Улсын харьятаас гаргасан иргэний мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1.-2.1.3.-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулсан байна:

- 3.1.1.иргэний үнэмлэх /гадаад паспортын/ дугаар;
- 3.1.2.регистрийн дугаар;
- 3.1.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн он, сар, өдөр, дугаар;
- 3.1.4.Монгол Улсын харьяатаас гаргасан үндэслэл;
- 3.1.5.харьяат болсон улс;
- 3.1.6.гэр бүлийн гишүүний мэдээлэл;
- 3.1.7.боловсрол, мэргэжил

3.2.Монгол Улсын харьяат болсон иргэний мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1.- 2.1.3 -д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулсан байна:

- 3.2.1.регистрийн дугаар;
- 3.2.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн он, сар, өдөр, дугаар;
- 3.2.3.Монгол Улсад оршин суугаа хаяг;
- 3.2.4.өмнө нь харьяаллагдаж байсан улс;
- 3.2.5.гэр бүлийн гишүүд;
- 3.2.6.ажил эрхлэлтийн мэдээлэл;
- 3.2.7.боловсрол, мэргэжил.

3.3.Иргэний харьяаллаа сэргээр тогтоолгосон иргэдийн мэдээллийн сан нь энэ журмын 3.2-д заасан мэдээллийг агуулна.

3.4.Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэний мэдээллийн сан нь журмын 2.1.1-2.1.3-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулсан байна:

- 3.4.1.иргэний үнэмлэх /гадаад паспортын/ дугаар;
- 3.4.2.Монгол Улсад оршин суух хаяг;
- 3.4.3.давхар харьяалагдах улс, тухайн улсад оршин суух хаяг;
- 3.4.4.шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага, шийдвэрийн дугаар, он, сар, өдөр.

3.5. Гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн мэдээллийн сан дараах мэдээллийг агуулна:

3.5.1.хүүхдийн талаарх мэдээлэл:

- 3.5.1.1.журмын 2.1.1-2.1.3-д заасан мэдээлэл;
- 3.5.1.2.зураг;
- 3.5.1.3.регистрийн дугаар;
- 3.5.1.4.төрсний гэрчилгээний дугаар;
- 3.5.1.5.үрчлүүлэхийг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэрийн он, сар,

өдөр, дугаар;

3.5.1.6.үрчлэгдсэн он, сар, өдөр.

3.5.2.үрчилж авсан эцэг, эхийн талаарх мэдээлэл:

- 3.5.2.1.журмын 2.1.1-2.1.4-д заасан мэдээлэл;

3.5.2.2. оршин суух хаяг;

3.5.2.3. оршин суугаа үлдсэн иргэний үнэмлэх/паспорт/, регистрийн дугаар.

Дөрөв. Гадаадын иргэдний хяналт, шалгалтын мэдээллийн сан

4.1. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1.-2.1.8.-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулна:

- 4.1.1. албадан гаргах үндэслэл, эхлэх болон дуусах хугацаа;
- 4.1.2. албадан гаргасан тушаалын дугаар, он, сар, өдөр;
- 4.1.3. тушаалд өөрчлөлт өссөн он, сар, өдөр
- 4.1.4. гарын хурууны хээ болон зүрэг.

4.2. Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэний мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулна:

- 4.2.1. хүсэлт гаргасан байгууллагын нэр;
- 4.2.2. албан бичгийн дугаар, он, сар, өдөр;
- 4.2.3. албан бичгийг хүлээн авсан он, сар, өдөр;
- 4.2.4. гарахыг түдгэлзүүлсэн үндэслэл;
- 4.2.5. гарахыг түдгэлзүүлсэн шийдвэрийн дугаар, он, сар, өдөр;
- 4.2.6. түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон шийдвэрийн дугаар, он, сар, өдөр, байгууллага.

4.3. Ял шийтгэгдсэн гадаадын иргэний мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулна:

- 4.3.1. паспорт хадгалсан байгууллагын нэр;
- 4.3.2. Монгол Улсад оршин сууж байсан хаяг;
- 4.3.3. шүүхийн шийдвэрийн он, сар, өдөр;
- 4.3.4. Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, ялын төрөл;
- 4.3.5. ял эдлэх хугацаа;
- 4.3.6. ял эдэлж байгаа хорих ангийн дугаар;
- 4.3.7. хорих ял эдлэж дууссан талаарх мэдээлэл / он, сар, өдөр/;
- 4.3.8. хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн бол энэ тухай мэдээлэл.

4.4. Виз, бүртгэлийн журмын зөрчиж хариуцлага хүлээсэн гадаадын иргэний мэдээллийн сан нь энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг агуулна:

- 4.4.1. зөрчлийн төрөл, зөрчил гаргасан/илрүүлсэн он, сар, өдөр;
- 4.4.2. Монгол Улсад оршин суух хаяг, эрхэлсэн ажил;
- 4.4.3. захиргааны шийтгэлийн хэмжээний талаарх мэдээлэл:
 - 4.4.3.1. холбогдох хуулийн зүйл, заалт;
 - 4.4.3.2. шийтгэврийн дугаар, он, сар, өдөр;
 - 4.4.3.3. торгуулийн хэмжээ.

4.5. Захиргааны хариуцлага хүлээсэн уригч байгууллага, иргэний мэдээллийн нь дараах мэдээллийг агуулна:

- 4.5.1. уригч иргэний хувьд энэ журмын 2.3.1.-д заасан мэдээлэл;
- 4.5.2. уригч байгууллагын хувьд регистрийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, хаяг.

Тав. Мэдээллийн сангийн толгой компьютерийг ашиглах

5.1. Мэдээллийн сангийн толгой компьютер /сервер/ нь тоос шороо орохоос хамгаалагдсан, чийгшил, агааржуулалт, дулааны нөхцөл хангасан, цахилгаан соронзон долгионы цацралт, механик гэмтлээс хамгаалагдсан, техник, төхөөрөмж нь газардуулга бүхий зориулалтын өрөөнд байрлана.

5.2. Толгой компьютер нь 24 цагийн ажиллагаатай дотоод сүлжээнд холбогдсон байна.

5.3. Толгой компьютерийн өрөөнд дараах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байх үедээ орох эрхтэй:

5.3.1. Газрын дарга;

5.3.2. Дэд дарга;

5.3.3. хариуцсан нэгжийн дарга;

5.3.4. программ хангамж хариуцсан ажилтан.

5.4. Толгой компьютерийн мэдээллийг эрдэглээс хамгаалах зорилгоор нөөц толгой компьютертэй холбож мэдээллийн хуулбарыг тогтмол үүсгэж ажиллана.

5.5. Мэдээллийн сангийн өдөр тутмын ашиглалт, аюулгүй байдлыг программ хангамж хариуцсан ажилтан хариуцна.

Зургаа. Мэдээллийн санг ашиглах, мэдээлэл оруулах

6.1. Мэдээллийн санд хандах, мэдээлэл оруулах эрх бүхий алба хаагч тус бүр хэрэглэгчийн нэр, нууц үгтэй байна.

6.2. Мэдээллийн сангийн программ хангамж нь санд шинээр мэдээлэл оруулсан, байгаа мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт хийсэн хэрэглэгч бүрийг бүртгэх боломжтой хийгдсэн байна.

6.3. Мэдээллийн санд байгаа мэдээлэлд зөвхөн газрын даргын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу тусгайлан эрх олгосон албан тушаалтан засвар оруулна.

6.4. Мэдээллийн сангаас гадны бэйгууллага, иргэнд мэдээлэл, лавлагаа өгөх тохиолдолд хариуцсан нэгжийн даргын зөвшөөрлийг бичгээр авсан байна.

6.5. Орон нутгийн алба мэдээллийн санд зөвхөн мэдээлэл шинээр оруулах, мэдээллийг ашиглах боломжоор хангагдсан байх бөгөөд засвар оруулах шаардлага гарсан тохиолдолд тухайн албаны дарга Газрын даргаас бичгээр өгсөн зөвшөөрөл авсны үндсэн дээр биечлэн засварыг оруулна.

6.6. Мэдээллийн сантай холбоотой компьютерт нэмэлт программ суулгах, интернэтэд холбохыг хориглоно.

---oOo---

